



**БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН  
ХЭМЖЭЭГ НЭМЭГДҮҮЛЭХ, ХОРОГДУУЛАХ, ШИНЭЭР ХУВЬЦАА ГАРГАХ,  
ХУДАЛДАХ, ШИЛЖҮҮЛЭХЭД МӨРДӨХ ЖУРАМ**

**НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

1.1. Банк бус санхүүгийн байгууллага (цаашид “ББСБ” гэх)-ын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх, хорогдуулах, шинээр хувьцаа гаргах, худалдах, шилжүүлэх, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах, хоёрдогч өглөгөөр эх үүсвэр татахтай холбоотой үүссэн харилцааг энэ журмаар зохицуулна.

**ХОЁР. ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ХЭМЖЭЭГ НЭМЭГДҮҮЛЭХ, ХОРОГДУУЛАХ,  
ХУВЬЦААГ ХУДАЛДАХ, ШИЛЖҮҮЛЭХЭД ТАВИГДАХ ШААРДЛАГА**

2.1. Эцсийн өмчлөгч, хувьцаа эзэмшигчээс оруулах мөнгөн хөрөнгө нь бусдын өмнө үүрэг хүлээгээгүй, тухайн этгээд, түүнтэй холбогдох этгээдийн хууль ёсны орлогоор бүрдүүлсэн, татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлагнасан орлого байна.

2.2. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтэц, хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнд Компанийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2-т зааснаас гадна дараах байдлаар өөрчлөлт оруулна:

2.2.1. хувьцаа эзэмшигч нь хувьцаагаа бэлэглэх, өвлүүлэх, эсхүл бусад хувьцаа эзэмшигчид болон гуравдагч этгээдэд худалдах;

2.2.2. хугацааны эцэст хувьцаанд хөрвүүлэх хоёрдогч өглөг;

2.2.3. хууль болон холбогдох журамд заасан бусад хэлбэрээр нэмэгдүүлэх;

2.2.4. Хорооноос тогтоосон хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээ, зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг хангаж, санхүү, төлбөрийн чадварт сөргөөр нөлөөлөхгүй, хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулснаар бусад хувьцаа эзэмшигч, харилцагчдад хохирол учруулахгүй бол хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг хорогдуулах.

2.3. Энэ журмын 2.2.1-д заасны дагуу хувьцаа эзэмшигч нь өөрийн эзэмшлийн нэгж хувьцааг нэрлэсэн үнээс багаар худалдах тохиолдолд хөрөнгийн үнэлгээний компаниар нэгж хувьцааны үнэлгээг тогтоолгосон байна.

2.4. Нээлттэй хувьцаат компани хэлбэрээр үйл ажиллагаа явуулж буй ББСБ нь хаалттай хүрээнд нэмж хувьцаа гаргах, аливаа этгээд дангаар болон холбогдох этгээдийн хамт ББСБ-ын нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болох, ББСБ-ын нөлөө бүхий хувьцаа эзэмшигчийн хувьцааны хэмжээ, бүтцэд өөрчлөлт оруулах тохиолдолд энэ журмын 2.1-д заасан шаардлагыг хангах ба Хорооны шийдвэр гарсны дараа холбогдох гүйлгээг хийж, бүртгүүлнэ.

2.5. Хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүн, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтцэд өөрчлөлт оруулах зөвшөөрлийн хүсэлт гаргаж буй ББСБ хувь нийлүүлэх мөнгөн хөрөнгийг байршуулсан хувьцаа эзэмшигчийн данснаас зарлагын гүйлгээ хийхгүй бөгөөд Хорооны даргад танилцуулж, шийдвэрлүүлэхээс өмнө дансны үлдэгдэлд өөрчлөлт оруулсан эсэхийг дахин баталгаажуулж болно.

2.6. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5-д заасны дагуу

ББСБ нь хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүн, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтцэд өөрчлөлт оруулах тухай бүр Хорооны даргын шийдвэрийг үндэслэн холбогдох гүйлгээг хийнэ.

2.7.ББСБ хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүн, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтцэд өөрчлөлт оруулах хүсэлтээ энэ журмын нэгдүгээр хавсралтаар баталсан өргөдлийн маягтын дагуу гаргаж, хоёрдугаар хавсралтад заасан баримт бичгийг хавсаргаж Хороонд ирүүлнэ.

2.8.Хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүн, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтцэд өөрчлөлт оруулах тухай зөвшөөрөл олгож, тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хавсралтад зохих тэмдэглэгээг хийж баталгаажуулсны дараа Улсын бүртгэлийн байгууллагад холбогдох бүртгэлийг хийлгэнэ.

2.9.ББСБ өөрчлөлт орсон улсын бүртгэлийн гэрчилгээ болон дүрмийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбарыг Хороонд ирүүлнэ.

### ГУРАВ. ХОЁРДОГЧ ӨГЛӨГӨӨР ЭХ ҮҮСВЭР ТАТАХАД ТАВИГДАХ ШААРДЛАГА

3.1.ББСБ өөрийн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор хоёрдогч өглөг хэлбэрээр энэ журмын 2.1-д заасан шаардлагыг хангасан мөнгөн хөрөнгийг гуравдагч этгээдээс гэрээний үндсэн дээр гурваас доошгүй жилийн хугацаатай татан төвлөрүүлэхээр шийдвэрлэсэн тохиолдолд энэхүү журмын гуравдугаар хавсралтаар баталсан өргөдлийн маягтыг бөглөн дөрөвдүгээр хавсралтад заасан баримт бичгийн хамт Хороонд ирүүлнэ.

3.2.Хороо хоёрдогч өглөгөөр татан төвлөрүүлж буй мөнгөн хөрөнгийн гарал үүслийг шалган энэ журмын 2.6-д заасны дагуу шийдвэрлэнэ.

3.3.Хоёрдогч өглөгийн гэрээнд дараах зүйлийг заавал тусгана:

3.3.1.гэрээ байгуулсан огноо, гэрээний дугаар;

3.3.2.хоёрдогч өглөг байршуулах этгээдийн нэр, иргэний болон улсын бүртгэлийн дугаар, хаяг утас;

3.3.3.хоёрдогч өглөгөөр байршуулах мөнгөн хөрөнгийн хэмжээ, гэрээний хүү, хугацаа;

3.3.4.хоёрдогч өглөгийг хувьцаанд хөрвүүлэх нөхцөл;

3.3.5.талуудын эрх, үүрэг, хүлээх хариуцлага.

3.4.Хоёрдогч өглөгийг хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийг үндэслэн хувьцаанд хөрвүүлэх эсэхийг шийдвэрлэх ба хугацааны эцэст гэрээнд заасан нөхцөлийн дагуу хувьцаанд хөрвүүлэх тохиолдолд энэ журмын 2.6-д заасны дагуу Хороонд хандаж зөвшөөрөл авах ба хувьцаанд хөрвүүлэхгүй тохиолдолд өр төлбөрийг барагдуулж, гэрээний харилцаа дуусгавар болсныг Хороонд мэдэгдэнэ.

3.5.Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон, дампуурсан, төлбөрийн чадваргүй болсныг зарласан, өөрчлөн байгуулснаас бусад тохиолдолд хоёрдогч өглөгийн үндсэн өрийг хугацаанаас нь өмнө барагдуулахгүй.

“Банк бус санхүүгийн байгууллагын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх, хорогдуулах, шинээр хувьцаа гаргах, худалдах, шилжүүлэхэд мөрдөх журам”-ын нэгдүгээр хавсралт

**БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮРЭЛДЭХҮҮН, ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ХЭМЖЭЭ, БҮТЦЭД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ЗӨВШӨӨРӨЛ ХҮСЭХ ӨРГӨДӨЛ**

|  |   |   |  |                          |                                      |                                    |                               |
|--|---|---|--|--------------------------|--------------------------------------|------------------------------------|-------------------------------|
| Өргөдөл гаргасан огноо   |   | Он  |  | Сар                      |                                      | Өдөр                               |                               |
| Өргөдөл/хүсэлт гаргагч ББСБ-ын оноосон нэр   |   |   |  |                          |                                      |                                    |                               |
| Регистрийн дугаар  |   |   |  |                          |                                      |                                    |                               |
| <b>Хэсэг 1. Хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүн, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтцэд өөрчлөлт оруулах</b>  |   |   |  |                          |                                      |                                    |                               |
| Хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах<br>Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд өөрчлөлт оруулах<br>Хувь нийлүүлсэн хөрөнгийн бүтцэд өөрчлөлт оруулах |   |   |  |                          |                                      |                                    |                               |
| <b>А. Хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнд шинээр орж буй этгээдийн хувьд:</b>  |   |   |  |                          |                                      |                                    |                               |
| Оноосон нэр (Овог, нэр)  | Харьяалал                               | РД  | Хувьцааны тоо (ш)                          | ХНХ хэмжээ (₮)           | ХНХ-д эзлэх хувь (%)                 | Хаяг, утас                         |                               |
|  |   |   |  |                          |                                      |                                    |                               |
| Тэмдэглэл: (Дээрх мэдээллийг хувьцаа эзэмшигч бүрээр бичнэ.)   |   |   |  |                          |                                      |                                    |                               |
| <b>Б. Хувьцаа эзэмшигчдийн хувь нийлүүлсэн хөрөнгөд өөрчлөлт орсон тохиолдолд:</b>   |   |   |  |                          |                                      |                                    |                               |
| Д/д  | Оноосон нэр (Овог, нэр)                 | РД  | Одоогийн ХНХ хэмжээ (₮)                    | Нэмэгдсэн, Хорогдсон (₮) | Өөрчлөлт орсны дараах ХНХ хэмжээ (₮) | ХНХ-д эзлэх хувь (%)               |                               |
| Хуулийн этгээд   |   |   |  |                          |                                      |                                    |                               |
| Иргэн  |   |   |  |                          |                                      |                                    |                               |
| Тэмдэглэл: (Дээрх мэдээллийг хувьцаа эзэмшигч бүрээр бичнэ.)   |   |   |  |                          |                                      |                                    |                               |
| <b>В. Хувьцаа эзэмшигч нь хуулийн этгээд бол эцсийн өмчлөгчийн талаарх мэдээлэл</b>  |   |   |  |                          |                                      |                                    |                               |
| Хуулийн этгээдийн нэр  | Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн нэр | РД  | Хуулийн этгээдийн хувьцааны эзэмшлийн хувь | Хаяг, холбоо барих утас  |                                      |                                    |                               |
|  |   |   |  |                          |                                      |                                    |                               |
| <b>Г. Шинэ хувьцаа эзэмшигч компанийн нэгдлийн мэдээлэл</b>  |   |   |  |                          |                                      |                                    |                               |
| Компанийн тухай хуулийн 6.14-д заасан компанийн нэгдлийн оролцогч эсэх?  |   |   |  |                          | Тийм <input type="checkbox"/>        |                                    | Үгүй <input type="checkbox"/> |
| Тийм бол доорх мэдээллийг нэгдлийн оролцогч бүрээр бөглөнө үү.   |   |   |  |                          |                                      |                                    |                               |
| Оноосон нэр  |   | Хувьцаат компани  |  |                          | Хязгаарлагдмал хариуцлагатай компани |                                    |                               |
| Компанийн хэлбэр   |   | Тусгай зөвшөөрөл хүсэгч компанитай ямар холбоотой болох |  |                          | Толгой <input type="checkbox"/>      | Хараат <input type="checkbox"/>    |                               |
|  |   |   |  |                          | Охин <input type="checkbox"/>        | Зэргэлдээ <input type="checkbox"/> |                               |
| Байгуулагдсан огноо  |   | Он  |  | Сар                      |                                      | Өдөр                               |                               |
| Үйл ажиллагааны төрөл  |   |   |  |                          |                                      |                                    |                               |
| Хаяг   |   | Аймаг/ хот  |  |                          |                                      |                                    |                               |
|  |   | Сум/дүүрэг  |  |                          |                                      |                                    |                               |
|  |   | Баг/хороо   |  |                          |                                      |                                    |                               |
|  |   | Гудамж, байр  |  |                          |                                      |                                    |                               |
|  |   | Тоот  |  |                          |                                      |                                    |                               |
| Холбоо барих утас  |   |   |  |                          |                                      |                                    |                               |
| Цахим хуудас   |   |   |  |                          |                                      |                                    |                               |
| Цахим хаяг   |   |   |  |                          |                                      |                                    |                               |

“Банк бус санхүүгийн байгууллагын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх, хорогдуулах, шинээр хувьцаа гаргах, худалдах, шилжүүлэхэд мөрдөх журам”-ын хоёрдугаар хавсралт

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮРЭЛДЭХҮҮН, ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ХЭМЖЭЭ, БҮТЦЭД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ӨРГӨДӨЛД ХАВСАРГАХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ

| № | Баримт бичгийн төрөл  | Хуудасны тоо |
|---|---|--------------|
| 1 | Өөрчлөлт оруулахыг зөвшөөрсөн хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэл, шийдвэр, холбогдох гэрээ хэлцэл, нотлох баримт бичиг   |              |
| 2 | Иргэний хуулийн дагуу өмчлөх эрхээ өвлүүлсэн, бэлэглэсэнтухай хэлцэл, нотлох баримт бичиг   |              |
| 3 | Хувьцаагаа худалдахаар санал болгож байгаа хувьцаа эзэмшигчийн хүргүүлсэн саналыг бусад хувьцаа эзэмшигчдэд мэдэгдсэн албан бичгийн хуулбар   |              |
| 4 | Шинээр орж буй хувьцаа эзэмшигчийн хувьд хувь нийлүүлсэн хөрөнгөд оруулах мөнгөн хөрөнгийн гарал үүслийн талаарх тодорхойлолт, хууль ёсны үйл ажиллагаанаас олсон орлогоос бүрдэж буйг нотлох баримт бичиг            |              |
| 5 | Хувь нийлүүлсэн хөрөнгөд оруулах мөнгөн хөрөнгийг дансанд байршуулсан болохыг тодорхойлсон банкны тодорхойлолт, дансны хуулга   |              |
| 6 | ББСБ нь хувь хөрөнгөө хуримтлагдсан ашгаар нэмэгдүүлж буй тохиолдолд тухайн жилүүдийн аудитлагдсан санхүүгийн тайлан, харьяалах татварын байгууллагаас баталгаажуулсан аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайлан |              |
| 7 | Нэмэлт өөрчлөлт оруулсан дүрмийн эх хувь  |              |
| 8 | Шаардлагатай бусад  |              |

“Банк бус санхүүгийн байгууллагын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх, хорогдуулах, шинээр хувьцаа гаргах, худалдах, шилжүүлэхэд мөрдөх журам”-ын гуравдугаар хавсралт

**ХОЁРДОГЧ ӨГЛӨГӨӨР ЭХ ҮҮСВЭР ТАТАН ТӨВЛӨРҮҮЛЭХ ӨРГӨДӨЛ**

|   |   |                   |  |                         |            |         |
|---|---|-------------------|--|-------------------------|------------|---------|
| Өргөдөл гаргасан огноо  | Он                                      |                   | Сар                                      |                         | Өдөр       |         |
| Өргөдөл/хүсэлт гаргагч ББСБ-ын оноосон нэр                                      |   |                   |  |                         |            |         |
| Регистрийн дугаар   |   |                   |  |                         |            |         |
| <b><i>А. Хоёрдогч өглөгийн гэрээгээр хөрөнгө оруулах этгээдийн мэдээлэл</i></b> |   |                   |  |                         |            |         |
| Д/д   | Оноосон нэр/<br>Овог нэр                | Харьяалал         | Улсын<br>бүртгэлийн<br>н дугаар          | РД                      | Хэмжээ (₮) | Хугацаа |
| Хуулийн этгээд  |   |                   |  |                         |            |         |
| Иргэн   |   |                   |  |                         |            |         |
| <b><i>Тэмдэглэл: (Дээрх мэдээллийг хуулийн этгээд, иргэн бүрээр бичнэ.)</i></b> |   |                   |  |                         |            |         |
| <b><i>Б.Хуулийн этгээд бол эцсийн өмчлөгчийн талаарх мэдээлэл</i></b>           |   |                   |  |                         |            |         |
| Хуулийн этгээдийн нэр   | Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн нэр | Регистрийн дугаар | Хуулийн этгээдийн хувьцааны эзэмшил хувь | Хаяг, холбоо барих утас |            |         |
|   |   |                   |  |                         |            |         |
|   |   |                   |  |                         |            |         |

“Банк бус санхүүгийн байгууллагын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх, хорогдуулах, шинээр хувьцаа гаргах, худалдах, шилжүүлэхэд мөрдөх журам”-ын дөрөвдүгээр хавсралт

ХОЁРДОГЧ ӨГЛӨГӨӨР ЭХ ҮҮСВЭР ТАТАН ТӨВЛӨРҮҮЛЭХ ӨРГӨДӨЛД  
ХАВСАРГАХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ

| № | Бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт  | Хуудасны тоо |
|---|--|--------------|
| 1 | Өөрийн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор хоёрдогч өглөг хэлбэрээр эх үүсвэр татан төвлөрүүлэх тухай хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэл, шийдвэр |              |
| 2 | Хоёрдогч өглөгийн гэрээ  |              |
| 3 | Хөрөнгө оруулж буй мөнгөн хөрөнгийн гарал үүсэл, хууль ёсны орлогоос бүрдэж буйг нотлох баримт бичиг   |              |